



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Могод сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/52/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Булган хот 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: Anhbayrd@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enhtsoodol@audit.gov.mn</p> <p>Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: Suvdaaa@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Залруулсан алдаа	14
4.2 Албан шаардлага	14
4.3 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нийцлийн аудит
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 67.
танай _____ ны № _____ т

МОГОД СУМЫН СОЁЛЫН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ Б.НЭРГҮЙ
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Могод сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Могод сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot

00600094

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,815,912.76	15,860,982.76
35	БАРАА МАТЕРИАЛ	14,815,912.76	15,860,982.76
354	Хангамжийн материал	14,815,912.76	15,860,982.76
35410	Бичиг хэргийн материал	314,550.00	297,220.00
35420	Аж ахуйн материал	2,732,650.00	3,795,050.00
35470	Бусад хангамжийн материал	11,768,712.76	11,768,712.76
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	157,251,771.96	135,453,483.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	157,251,771.96	135,453,483.57
392	Биет хөрөнгө	155,802,771.96	133,231,150.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	168,111,849.65	168,111,849.65
39202	Хуримтлагдсан элэгдэл	(39,592,409.85)	(63,091,644.09)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	18,641,258.70	24,636,258.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(11,925,666.42)	(15,116,104.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,768,736.67	21,768,736.67
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,229,739.47)	(19,700,713.13)
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,386,000.00	5,386,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,994,616.32)	(4,400,591.79)
39217	Ном	15,637,359.00	15,637,359.00
393	Биет бус хөрөнгө	1,449,000.00	2,222,333.30
39301	Програм хангамж	300,000.00	1,300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(195,000.00)	(421,666.70)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,344,000.00	1,344,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	172,067,684.72	151,314,466.33
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	172,067,684.72	151,314,466.33
51	Засгийн газрын хувь оролцоо	172,067,684.72	151,314,466.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	86,176,627.13	86,176,627.13
51101	Өмч: - төрийн	86,176,627.13	86,176,627.13
512	Хуримтлагдсан үр дүн	(90,132,867.06)	(110,886,085.45)
51210	Өмнөх үеийн үр дүн	(90,132,867.06)	(90,132,867.06)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(20,753,218.39)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	176,023,924.65	176,023,924.65
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	172,067,684.72	151,314,466.33

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	83,874,800.00	89,937,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	617,300.00	6,495,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	617,300.00	6,495,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	617,300.00	6,495,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	617,300.00	500,000.00

**Могод сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө		5,995,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	83,257,500.00	83,442,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	83,257,500.00	83,442,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	83,257,500.00	83,442,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	106,663,444.73	110,690,818.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	106,663,444.73	110,690,818.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	104,283,404.90	110,033,979.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	49,674,416.07	50,132,087.45
210101	Үндсэн цалин	39,242,005.27	39,730,323.95
210102	Нэмэгдэл	10,432,410.80	10,401,763.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,209,301.10	6,613,128.46
210201	Тэтгэврийн даатгал	4,222,325.06	4,607,286.78
210202	Тэтгэмжийн даатгал	496,893.02	501,635.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	397,392.39	400,668.25
210204	Ажилгүйдлийн даатгал	99,345.62	100,267.17
210205	Эрүүл мэндийн даатгал	993,345.01	1,003,270.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,132,985.00	23,184,407.00
210301	Гэрэл, цахилгаан	182,985.00	234,407.00
210302	Түлш, халаалт	22,950,000.00	22,950,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,002,060.00	1,054,068.00
210401	Бичиг хэрэг	174,560.00	75,330.00
210402	Тээвэр, шатахуун	245,000.00	299,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	275,000.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	47,638.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	110,000.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,197,500.00	557,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	290,500.00	-
210604	Урсгал засвар	290,500.00	-
2107	Томилолт, зочны зардал	42,000.00	40,000.00
210702	Дотоод албан томилолт	42,000.00	40,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	345,758.00	217,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	237,758.00	217,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,586,384.73	28,793,288.39
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,586,384.73	28,793,288.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,380,039.83	656,839.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,280,039.83	656,839.09
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,280,039.83	656,839.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(22,788,644.73)	(20,753,218.39)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(22,788,644.73)	(20,753,218.39)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон						/төгсгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	86,176,627.13	176,023,924.65	(90,132,867.06)	172,064,684.72	344,132,369.44
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	86,176,627.13	176,023,924.65	(90,132,867.06)	172,064,684.72	344,132,369.44
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	86,176,627.13	176,023,924.65	(90,132,867.06)	172,064,684.72	344,132,369.44
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	86,176,627.13	176,023,924.65	(90,132,867.06)	172,064,684.72	344,132,369.44
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	86,176,627.13	176,023,924.65	(90,132,867.06)	172,064,684.72	344,132,369.44
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(20,753,218.39)	(20,753,218.39)	(41,506,436.78)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	86,176,627.13	176,023,924.65	(110,886,085.45)	151,311,466.33	302,625,932.66

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	83,874,800.00	83,942,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	617,300.00	500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	617,300.00	500,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	617,300.00	500,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	617,300.00	500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	83,257,500.00	83,442,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	83,257,500.00	83,442,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	83,257,500.00	83,442,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	83,874,800.00	82,942,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	83,874,800.00	82,942,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	81,494,760.17	82,285,760.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	49,674,416.07	50,132,087.45
210101	Үндсэн цалин	39,242,005.27	39,730,323.95
210102	Нэмэгдэл	10,432,410.80	10,401,763.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,209,301.10	6,613,128.46
210201	Тэтгэврийн даатгал	4,222,325.06	4,607,286.78
210202	Тэтгэмжийн даатгал	496,893.02	501,635.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	397,392.39	400,668.25
210204	Ажилгүйдлийн даатгал	99,345.62	100,267.17
210205	Эрүүл мэндийн даатгал	993,345.01	1,003,270.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,132,985.00	23,184,407.00
210301	Гэрэл, цахилгаан	182,985.00	234,407.00
210302	Түлш, халаалт	22,950,000.00	22,950,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	492,900.00	280,638.00
210401	Бичиг хэрэг	48,500.00	58,000.00
210402	Тээвэр, шатахуун	117,900.00	100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	275,000.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	47,638.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	51,500.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	299,660.00	357,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	57,500.00
210604	Урсгал засвар	299,660.00	300,000.00
2107	Томилолт, зочны зардал	169,100.00	40,000.00
210702	Дотоод албан томилолт	169,100.00	40,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,516,398.00	1,678,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,408,398.00	1,678,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,380,039.83	656,839.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,280,039.83	656,839.09
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,280,039.83	656,839.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	1,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	1,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,000,000.00

**Могод сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

223001	Бусад хөрөнгө	-	1,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(1,000,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	83,942,600.00	83,285,760.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	83,942,600.00	83,285,760.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	83,942,600.00	83,285,760.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	50,171,500.00	50,132,087.45
210101	Үндсэн цалин	39,730,800.00	39,730,323.95
210102	Нэмэгдэл	10,440,700.00	10,401,763.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,773,200.00	6,613,128.46
210201	Тэтгэврийн даатгал	4,766,400.00	4,607,286.78
210202	Тэтгэмжийн даатгал	501,700.00	501,635.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	401,400.00	400,668.25
210204	Ажилгүйдлийн даатгал	100,300.00	100,267.17
210205	Эрүүл мэндийн даатгал	1,003,400.00	1,003,270.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,226,900.00	23,184,407.00
210301	Гэрэл, цахилгаан	276,900.00	234,407.00
210302	Түлш, халаалт	22,950,000.00	22,950,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	325,000.00	280,638.00
210401	Бичиг хэрэг	60,000.00	58,000.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	47,638.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	380,000.00	357,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	80,000.00	57,500.00
210604	Урсгал засвар	300,000.00	300,000.00
2107	Томилолт, зочны зардал	58,000.00	40,000.00
210702	Дотоод албан томилолт	58,000.00	40,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,008,000.00	2,678,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,900,000.00	1,678,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	83,442,600.00	83,942,600.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	83,442,600.00	83,442,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	83,442,600.00	83,442,600.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	500,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	500,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Нэмэлт санхүүжилт гараагүй болно.

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Могод сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 10-аас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Сувдаа гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хэрэгжүүлсэн.

Могод сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго нь Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгон, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг стандарт технологийн дагуу үзүүлж тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулж иргэдийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, мэдлэг хандлагыг нэмэгдүүлэхэд оршино

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналдаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг аймгийн Засаг даргын А/424 тоот захирамжаар 2020 онд батлуулж Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг тусгасан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Могод сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 106,663.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1.599.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлаар тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Могод сумын Соёлын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20,753.2 мянган төгрөгөөр буюу 12.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан машин тоног төхөөрөмж, тайлант үеийн үр дүнгийн болон үндсэн хөрөнгийн элэгдэл данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Урьдчилж гарсан тооцоо	0.0	0.0	0.0
Бараа материал	14815.9	15861.0	1045.1
Үндсэн хөрөнгө	157251.8	135453.5	-21798.3
Нийт хөрөнгө	172067.7	151314.5	-20753.2
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Хуримтлагдсан үр дүн	172067.7	151314.5	-20753.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	172067.7	151314.5	-20753.2

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Машин тоног төхөөрөмж 5,995.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Тайлант үеийн үр дүн 20,753.2 мянган төгрөгөөр буурсан;
- Үндсэн хөрөнгө данс тайлант оны элэгдлийн зардлаас голлон шалтгаалж 23,499.2 мянган төгрөгөөр буурсан;

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	83,874.80	89,937.60	6,062.80	7.2%
12	Татварын бус орлого	617.30	6,495.00	5,877.70	952.2%
120004	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	617.30	6,495.00	5,877.70	952.2%
13	Тусламж, санхүүжилтийн орлого	83,257.50	83,442.60	185.10	0.2%
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	83,257.50	83,442.60	185.10	0.2%
2	Үйл ажиллагааны зардлын дүн	106,663.44	110,690.82	4,027.37	3.8%
21	Урсгал зардал	106,663.44	110,690.82	4,027.37	3.8%
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	104,283.40	110,033.98	5,750.57	5.5%

Могод сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213	Урсгал шилжүүлэг	2,380.04	656.84	(1,723.20)	-72.4%
3	Үйл ажиллагааны үр дүн /3=1-2/	(22,788.64)	(20,753.22)	2,035.43	-8.9%
5	Нийт үр дүн /5=3+4/	(22,788.64)	(20,753.22)	2,035.43	-8.9%

Могод сумын Соёлын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 5,877.7 мянган төгрөгөөр буюу 9.5 дахин нэмэгдэж, үйл ажиллагааны орлого өмнөх оноос 6,062.8 мянган төгрөг буюу 7.2 хувиар өссөж, үйл ажиллагааны зардал 4,027.4 мянган төгрөгөөр буюу 3.8 хувиар өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Могод сумын Соёлын төвийн 2021 оны санхүүжилтийн эх үүсвэрийг 110,830.3 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 110,830.3 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Сангийн яамнаас урсгал зардлыг 26,887.7 мянган төгрөгөөр бууруулж 83,942.6 мянган төгрөгөөр баталж тодотголоор өөрчлөлт ороогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 83,442.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үндсэн дансаар орон нутгийн төсвөөс 83,442.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 500.0 мянган төгрөгөөр, 83,285.8 мянган төгрөгийг зарцуулж 99.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 83,285.8 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, эд хогшил урсгал засварын зардал, томилолтын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг нийт 656.8 мянган төгрөгийг дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулалт нь үйл ажиллагааны урсгал зардал 656.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71702	Соёл урлаг	83,942.6	83,942.6	0.0	100.0%
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	82,042.6	82,042.6	0.0	100.0%
1.2	80214	ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	1,900.0	1,900.0	0.0	100.0%
1.3	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	0.0	0.0	0.0	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа үлдэх өртөггүй элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.

3.8 Аудитын гол асуудал

Могод сумын Соёлын төвийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан local.audit.mn цахим бүртгэлийн хүрээнд мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Могод сумын Соёлын төвийн 2021 онд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын нийт 67,434.2 мянган төгрөгийн 9 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас орлогын 67,434.2 мянган төгрөгийн 9 мэдээллийг ил тод байршуулаагүй, гуравдугаар улирлын төсвийн гүйцэтгэлийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 төлбөрийн акт, 4 албан шаардлагын 5 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	5700.0	2	5700.0	0	0	0
Нийт дүн	2	5700.0	2	5700.0	0	0	0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн эсэхийг нягтлах, биелэлтийг тооцох.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6.944.5 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 5,995.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 339.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 609.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 3 алдаа, зөрчлийн дүн 949.5 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 1.599.9 мянган төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Үнэ төлбөргүй ирсэн 5,995.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэл буруу хөтөлж журнал бүртгэсэн

4.2 Албан шаардлага

1. Тайлант хугацааны 339.7 мянган төгрөгийн соёлын төвийн эрхлэгч ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 4-д "Энэ журмыг үндэслэн тухайн салбар, мэргэжлийн онцлогийг харгалзан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг салбарын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран тогтооно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, холбогдох хууль, тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах, Албан шаардлага өгөх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 9 удаагийн 67,434.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасныг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтгүй нийт 609.8 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн, харилцагч 7 байгууллага, иргэнтэй тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтыг хэрэгжүүлж байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16.5.4, НББ-ийн тухай хуулийн 20.2.5-д заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
				Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Могод сумын Соёлын төв	4	6.944.5	1	5,995.0	0	0	1	339.7	0	0	3	1.115.2